

ГАРЧИГ

<i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	3
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт, горим	5
1.3. Ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт.....	6
1.4. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц.....	7
1.5. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	7
<i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i>	8
<i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i>	10
3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим	10
3.2. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим.....	13
<i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</i>	14
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	17
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	19
4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал.....	20
4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	21
4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....	25
4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	25

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт.....	3
Хүснэгт 2. Төсөл хэрэгжих талбайн солбилцол.....	4
Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө.....	5
Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим.....	6
Хүснэгт 5. Ил уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн сонголт.....	6
Хүснэгт 6. Уурхайд ашиглагдах цахилгаан үүсгүүрүүд.....	7
Хүснэгт 7. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	10
Хүснэгт 8. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах	12
Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл.....	13
Хүснэгт 10. Гол сөрөг нөлөөлөл.....	13
Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй.....	26

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	4
--	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тайлбар
1	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	“Мөнх ноён суварга” ХХК
2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Зайсан, “Гэгээнтэн цогцолбор” 202-р байр, 1502 тоот. Утас: (976)-7555-1221, 7555-1331
3	Төслийн нэр	Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт орших Цант-Уул чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах
4	Төсөл хэрэгжүүлэгчийн хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт	“Мөнх ноён суварга” ХХК 1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ: Улсын бүртгэлийн дугаар: 9011190142 Улсын регистрийн дугаар: 5314577 2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл: Дугаар: MV-016872
5	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн талбай	Талбайн хэмжээ: MV-016872 – 67992.5 га
6	Ордын геологийн (А+В+С) нөөц	Нүүрс: 96.13 сая.тн
7	Уурхайн жилийн хүчин чадал	Нүүрс: 1.5 сая.тн

Төслийн байршил: “Цант-Уул” чулуун нүүрсний орд нь Монгол орны өмнөд хэсэгт Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутагт УБ хотоос урагш 610 км, сумын төвөөс баруун хойш 45 км, Даланзадгад хотоос зүүн урагш 126 км, Гашуун Сухайт хилийн боомтоос 220 км-т оршино.

Талбайн солбицлын цэгүүд:

Хүснэгт 2. Төсөл хэрэгжих талбайн солбилцол

Цэгийн дугаар	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	105	47	1.35	43	13	16.35
2	105	47	1.34	43	10	1.36
3	106	0	1.41	43	10	1.36
4	106	0	1.39	43	0	1.34
5	105	49	18	43	0	1.34
6	105	49	18	43	4	6
7	105	46	13	43	4	6
8	105	46	13	43	3	1
9	105	48	46	43	3	1
10	105	48	46	43	0	1.34
11	105	36	1.33	43	0	1.34
12	105	36	1.35	43	13	16.35



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2. Уурхайн хүчин чадал, уулын ажлын төлөвлөлт, горим

1.2.1. Уурхайн жилийн хүчин чадал

Цант-Уул нүүрсний ил уурхайн хүчин чадал нь захиалагч компанийн техникийн даалгаварын дагуу жилд 1.5 сая.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулна.

Хүснэгт 3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Үзүүлэлт	Нийт хөрс хуулалт, м ³	Нийт нүүрс олборлолт, тн	Нийт уулын цул, м ³	Хөрс хуулалтын коэффициент, м ³ /тн
1-р сар				
2-р сар				
3-р сар				
4-р сар				
5-р сар				
6-р сар	365142	150428.57	468885.4	2.42
7-р сар	365142	150428.57	468885.4	2.42
8-р сар	365142	150428.57	468885.4	2.42
9-р сар	365142	150428.57	468885.4	2.42
10-р сар	365142	150428.57	468885.4	2.42
11-р сар	365142	150428.57	468885.4	2.42
12 - р сар	365142	150428.57	468885.4	2.42
Нийт	2559900	1053000	3282198	2.42

1.2.2. Уурхайн ажиллах горим

Уурхай нь жилд 240 өдөр, хоногт 2 ээлжтэй бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар тогтоосон горимоор ажиллана.

Хүснэгт 4. Уурхайн ажиллах горим

Үзүүлэлт	Нэгж	Хэмжээ
Жилд ажиллах календарь хоног	хоног	240
Хоног дахь ээлжийн тоо	ээлж	2
Ээлжийн үргэлжилэх хугацаа	цаг	12
Ээлж эхлэх хугацаа	цаг	0.5
Ээлж дуусах хугацаа	цаг	0.5
Цайны цаг	цаг	1
Ээлжинд ажиллах цаг	цаг	10

1.3. Ашиглалтын систем, тоног төхөөрөмжийн сонголт

1.3.1. Ашиглалтын системийн сонголт

Ордын уул геологийн нөхцлийг харгалзан үзэж уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор автосамосвал болон ачигч автосамосвалын хослол бүхий тээвэртэй ашиглалтын систем ашиглана. Хөрсийг гадаад овоолгод, нүүрсийг агуулах хүртэл тус тус тээвэрлэнэ.

Ашиглалтын системийн параметрууд

- ✓ Уурхайн нийт ажлын хажуугийн налууугийн өнцөг- 40°
- ✓ Уурхайн нийт ажлын бус хажуу ханын өнцөг- 15-40°
- ✓ Доголын налууугийн өнцөг- 55°
- ✓ Замуудын налуу нь хамгийн ихдээ 10%-иас, богино зайд 8%-иас ихгүй
- ✓ Замын өргөн- 25 м
- ✓ Овоолгыг 20 м-ийн ярусаар байгуулна. Гэхдээ эхний ярус нь газрын гадаргын бүтцээс хамааран 20-40 м хүртэл байх ба овоолго 2 ярустай байх юм
- ✓ Овоолгын нийт хажуугийн налуу- 20°
- ✓ Овоолгын ярусын хажуугийн налуу- 35°
- ✓ Шимт хөрсний овоолгийн хажуугийн налуу- 35°

1.3.2. Уулын үндсэн ажилд хэрэглэгдэх тоног төхөөрөмжүүд

Хүснэгт 5. Ил уурхайд ашиглах тоног төхөөрөмжийн сонголт

Тоног төхөөрөмж	Техникийн марк	Ашиглалтын жил
		2024
Экскаватор	Hitachi EX-1200	1
Утгуурт ачигч	CAT- 988 H	1
Автосамосвал	CAT- 773 F	2

1.4. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

1.4.1. Уурхайн бүрдэл, тэдгээрийн байршил

Цант-Уул нүүрсний ил уурхай үндсэн 4 хэсэг ба дагалдах хэсгүүдээс бүрдэнэ.

1. Ил уурхай:

Ил уурхай, тэсрэх материалын агуулах, хөрсний овоолго

2. Гадаад тээврийн хэсэг:

Тээврийн алба, дамжуулан ачих объект

3. Засвар үйлчилгээний хэсэг:

Засварын алба, шатахуун түгээх станц, зам арчилгааны алба

4. Тосгон, үйлчилгээний хэсэг:

Тосгон үйлчилгээний алба, эрүүл мэндийн төв, гал команд, харуул хамгаалалтын алба, холбоо

1.4.2. Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид ба үүсгэвэр

Уурхайн цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгчид нь гүний ус шүүрүүлэлтийн насос, уурхайн болон овоолгын гэрэлтүүлэг, засварын газрын тоног төхөөрөмжүүд, уурын зуух, уурхайн үйлдвэрлэлийн барилга байгууламжууд болон тосгоны ахуйн хэрэглэгчид хамаарна.

Хүснэгт 6. Уурхайд ашиглагдах цахилгаан үүсгүүрүүд

№	Цахилгаан үүсгүүр	Модель	Байрлал	Хүчин чадал		Тайлбар
				кВТ	кВА	
1	Т-409 дизель генератор	Teksan	Хотхон	327.2	409	
2	Т-275 дизель генератор	Teksan	Оффис	220	275	
3	Т-145 дизель генератор	Teksan	Хотхон	116	145	
4	Дизель генератор	KIPOR	Засварын газар	40/48	50/60	Нөөцөнд
5	OLY-88 дизель генератор	Olympian	Засварын газар	70.4	88	
6	OLY-50 дизель генератор	Olympian	Засварын газар	40	50	Нөөцөнд
7	Хятад дизель генератор	Хятад	Шатахуун түгээх станци	56		

1.5. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2024 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу 1.053 сая.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ус зүй. Судалгааны талбай нь Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд багтдаг. Тогтмол урсгалтай гол, горхи байхгүй. Хуурай сайр тойрмууд нь хур тунадас ихтэй үед усаар дүүрээд богино хугацаанд хөрс болон агаарт ууршин шингэдэг. Хүн малын усны хэрэгцээнд голлон худгийн ус хэрэглэнэ. Талбайн хэмжээнд нилээд хэдэн худагтай.

Уур амьсгал. Халуун зунтай, хуурайвтар уур амьсгалын мужид цасгүй, зөөлөвтөр өвөлтэй дэд мужид хамаардаг. Агаарын жилийн дундаж температур $+4^{\circ}\text{C}$ $+6^{\circ}\text{C}$, хамгийн халуун нь 7-р сард $+38^{\circ}\text{C}$ $+40^{\circ}\text{C}$, хамгийн хүйтэн нь 12-р сард -36°C -38°C хүрдэг. Агаарын чийгшилт, хур тунадас багатай жилд дунджаар 45-50% байгаа нь хуурайвтар болохыг харуулна. Ус чийг багатай, хуурай уур амьсгалтай. Хур тунадасны хэмжээ жилд дунджаар 133 мм байх ба үүний 70-80% нь 7-8-р сард унадаг. Өвөл цас маш бага, цасан бүрхүүл бараг тогтдоггүй бөгөөд 1-2 см, ихдээ 10 см зузаантай байдаг. Хоногийн температурын хэлбэлзэл ихтэй учир салхи, шороон шуурга ихтэй. Салхины дундаж хурд 4-6 м/с, салхины эрч хавар ширүүсдэг бөгөөд дунджаар 6 м/с, хамгийн бага салхилалт өвөл 4-4.5 м/с, жилд дунджаар 30-35 хоног 4 м/с хүртэл хүчтэй цасан ба шороо шуургатай өдрүүд тохиолдох ба энэ нь хавар, намар болж 5-7 хоног үргэлжлэх үе байдаг.

Хөрс. Ордын талбай нь говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг. Хур тунадас ховор, эрс гандуу уур амьсгалтай, өвс ургамал тачир сийрэг. Хөрс үүсэх явц гандуу нөхцөлд явагдах учир салхины үйл ажиллагаа хөрсний агаарын солилцоог идэвхжүүлж, ууршилтыг ихэсгэн хуурайшихад нөлөөлж өвс ургамлыг хийсгэн тараах тул зөвхөн үндэсний зарим нь ялзмаг болдгоос органик үлдэгдлийн хэмжээ маш бага, 1%-иас бараг үл хэтэрнэ. Иймээс сайр чулуу ихтэй хуурай хагсуу карбонатлаг байдгаас нийтлэг мараалаг шинж ажилагдаггүй.

Ургамалын бүрхэвч, амьтны аймаг. Говийн цаг уур, хөрсний онцлогоос шалтгаалан ургамлын нягтшил багатай, сийрэг тачир хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй, энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, шарилж, таана, мангир, хөмүүл, Монгол өвс, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, чихэр өвс, цулхир, гоёо зэрэг эмийн ургамал, хайлаас, тоорой, сухай, заг, жигд, зэгс, зээргэнэ, бударгана, хармаг, харгана гэх мэт модлог говь цөлийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирдэг. Говийн ургамал нь элсний нүүдэл, цөлжилтийн үйл явцыг тогтоон барьж байхад чухал ач холбогдолтой.

Энд говь цөлийн амьтад болох хар сүүлт зэрэг туурайтан, махчин амьтдаас хярс, үнэг, жигүүртнээс тас, элээ, ногтруу, хэвлээр явагчдаас олон зүйл гүрвэл, могой, мэрэгчдээс туулай, алаг даага, бозлог, шавьжаас хэд хэдэн төрлийн аалз, арваалж, ямаан ууц зэрэг ан амьтан нутагладаг.

Бүс нутгийн дэд бүтэц. Судалгааны талбайд хүн амын суурьшил харьцангуй бага. Орон нутгийн иргэд мал аж ахуй эрхлэн амьдардаг. Энэ сумын төв нь цахилгаан эрчим хүчний шугаманд холбогдсон, хүн эмнэлэг, мал эмнэлэг, үүрэн телефоны станц, 9 жилийн дунд сургууль, ШТС, дэлгүүр зэрэг газруудтай. Талбай нь бусад сум багтай шороон замаар холбогддог.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 7. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	x				x		x	x		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x		x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x			x					x
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал		x			x		x			x
Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x	x		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x				x		x	x		
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			x
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	x				x		x			x
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x			x			x
Хүчтэй салхи, уруйн үер										
Дүн	17	3		1	19		19	5	6	9

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нилээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавьж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төсөл хэрэгжих талбай болон орчны байдал, ТЭЗҮ-тэй танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэнд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 8. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим,
үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
1.Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				х
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				х
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		х		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				х
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			х	
4.Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			х	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			х	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		х		
5.Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтанд хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

3.2. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

“Цант-Уул” чулуун нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд нүүрс олборлох, ухаж ачих, тээвэрлэх үйл ажиллагаанууд хийгдэнэ.

Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

№	Үйл ажиллагааны хэлбэр Экологийн тогтолцоо	Эрэл хайгуул	Хөрс хуулах (хотхоны барилга, байгууламж)	Тэсэлгээ	Нүх, карьер ухах	Овоолго	Ачих тээвэрлэх	Бүгд
1	Агаар		2/3	9/9	8/8	3/3	4/5	26/28
2	Хөрс		2/5	10/10	10/10	6/6	2/3	30/34
3	Гадаргын ус							
4	Газрын доорхи ус							
5	Ургамал		5/5	9/9	9/9	8/8	2/3	33/34
6	Ан амьтан		1/1	1/1	2/2		1/3	5/7
7	Усны амьтан, ургамал							
8	Геологийн тогтоц		1/1	9/9	3/3		1/1	14/14
9	Байгалийн үзэсгэлэн		1/1	5/5	4/4	1/1		11/11
10	Бэлчээр		2/2	5/5	8/8	6/6	1/1	22/22
11	Хүний эрүүл мэнд		5/6	4/5	5/6	1/2		15/19
12	Бүгд		19/24	52/53	49/50	25/26	11/16	156/169

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүх, карьер ухах, овоолго хийх, ачих тээвэрлэх явц нь агаар, хөрс, ургамал, хүний эрүүл мэнд зэрэгт ихээхэн нөлөөлж болзошгүй нь харагдаж байна. Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, ургамал зэрэг юм.

Нөлөөлөлд орох байдлаар ангилбал агаар 26/28, ургамал 33/34, хөрс 30/34, бэлчээр 22/22 1-р ангилалд, геологийн тогтоц 14/14, хүний эрүүл мэнд 15/19 2-р ангилалд орж байна. Иймд 1 ба 2-р ангиллын өртөгчдөд нарийвчилсан судалгаа, тооцоо хийх нь зүйтэй.

Хүснэгт 10. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхайн үйл ажиллагаа болон овоолгоор хөрс, ургамал нь бүр мөсөн устаж, дахин сэргээгдэхгүйгээр үхжинэ.
2	Агаар	Нүүрсийг ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
3	Ургамал	Нийт талбайн ургамал бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Үүнд:

- ✓ Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- ✓ БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

4.1.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн гол болон тээврийн зам	км	20.0	5.0	100.0 x 40 удаа = 4 000.0	Зуны хуурай улиралд 7 хоногт 2 удаа	MNS 4585:2007” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5916:2008
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	ш	ОХШХ-ийн зардлаас		Жилд 2 удаа		
3		Нүүрсний өөрөө ноцолтыг хянах, нүүрс шатаж болзошгүй газруудад улирлаас хамаарч өдөрт 2-4 удаа биеэр шалгах, хянах	Нүүрсний агуулах, нүүрсний овоолгууд	удаа/жил	Үйл ажиллагааны зардлаас		Өдөрт 2-4 удаа		
Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Уурхай	Үйл ажиллагааны зардлаас			Жил бүрийн эхэнд	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.	
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх		Үйл ажиллагааны зардлаас			Үйл ажиллагааны турш		
3		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	ш	ОХШХ-ийн зардлаас		Улиралд 1 удаа		
Хөрсөн бүрхэвч									
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж,	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Овоолго	Үйл ажиллагааны зардлаас			Ашиглалтын явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008	
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Шимт хөрсний овоолго						

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	элэгдэл, эвдрэлд өртөнө.								“Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”
2	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу						
Газрын хэвлий									
1	Нүүрс олборлосоноор газрын хэвлийд хоосон орон зай шинээр үүсгэнэ.	Карьерын хананд хэвгийгүйжилт хийж гулсалт нуралтгүй болгон, урсгал усны үйл ажиллагааны нөлөөллөөр элэгдэл эвдрэл үүсэхээргүй болгон тогтвортой байдлыг хангах байдлаар техникийн нөхөн сэргээлт хийх	Ил уурхай	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар				Ашиглалтын явцад	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Ургамлан нөмрөг									
1	Уурхайгаас нүүрс олборлох, хөрс хуулах зэрэг ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэнд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолгын талбай	Ашиглалтын зардлаар				Ашиглалтын явцад	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага
2		Уурхайн нөлөөллийн бүсэд хээрийн судалгаа хийж ургамлын бичиглэл хийх	Уурхайн нөлөөллийн бүс	ОХШХ-ийн зардлаар				6-7-р сард	БОННУ-ний тайлан
3		“Тэрбум мод” үндэсний	Уурхайн	ш	20.0	500	10 000.0	10-р сард	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		хөтөлбөрийн хүрээнд уурхайн орчимд мод тарих	тосгон						
Амьтны аймаг									
1	Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Үйл ажиллагааны турш		Ашиглалтын зардлаас			2024 онд	Амьтны тухай хууль; 6.1.3.амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах; 6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;
2024 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын урьдчилсан дүн				14 000.0					

4.2.Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Гадаад овоолго	га	35.0	Ашиглалтын зардлаас			MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолго	га	0.5	14 380.0	14 380.0	5-10 сар	
3	Татан буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	
Нийт						14 380.0		

4.3.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Зэрлэг амьтдын амьдрах нөхцөлийг сайжруулах	Биотехникийн арга хэмжээ	Говийн их, бага ДЦГ-т ган, зудтай үед зэрлэг амьтдад өвс тавьж өгөх, худаг ус задгайлах, услах	2	15 000.0	30 000.0	2024 онд	БОННУ-ний тайлан, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
2	Усны эх үүсвэрийг хамгаалах	Булаг шандын эхийг хамгаалах, урсацыг сайжруулах	Аймгийн БОАЖГ болон Баян-Овоо сумын байгаль орчны байцаагчтай хамтран хэрэгжүүлэх	1	30 000.0	30 000.0	2024 онд	БОННУ-ний тайлан, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө
Нийт						60 000.0		

4.4.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2024 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.5.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Уурхай орчимд археологийн дурсгал илрээгүй болно.						
2	Палеонтологийн дурсгал	Уурхай орчимд палеонтологийн дурсгал илрээгүй болно.						

4.6.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гал түймэр	Галын булан байрлуулах	Уурхайн тосгон	2	3 000.0	6 000.0	2024 онд	MNS 6576 : 2016 Гал түймэртэй тэмцэх. Гал түймэр унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага
		Аваар устгах төлөвлөгөө боловсруулах	Уурхай	1	Үйл ажиллагааны зардлаас			Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм
2	Тэсрэх бодис	Мэргэжлийн гэрээт байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх	Тэсэлгээний ажлын үед	Ашиглалтын зардлаас				MNS 4223 : 1994 Тэсрэх бодис Техникийн шаардлага
		Тэсрэх бодисын тоо бүртгэлийг тогтмол хийх						
		Тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан аюулгүй болгох						
Нийт		6 000.0						

4.7.Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	Уурхай	ш	1 000.0	1	1 000.0	4-5-р сар	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, тогтмол тээвэрлүүлэх	Уурхай	сар	100.0	10	1 000.0	4-12-р сар	
2	Үйлдвэрийн	Хоосон чулуулгийн овоолго үүсгэн хадгалах	Уурхай	Ашиглалтын зардлаар				2024 онд	
3	Аюултай	Тэсрэх бодисын сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанид хүлээлгэн өгөх	Уурхай					2024 онд	
Нийт				2 000.0					

4.8.Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын болон дуу шуугианы хэмжилт хийх, хөрсний болон усны шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөсөн бөгөөд уг ажлыг гүйцэтгэх явцдаа нөлөөллийн бүсийн иргэд, орон нутгийн төлөөллийг байлцуулах шаардлагатай.

Хяналт-шинжилгээ хийх орчин ба үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийх хугацаа ба давтамж	Хэмжих нэгж	Нэгжийн тоо	Нэгжийн үнэ сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар							
Ялгарах бохирдуулагчид: SO ₂ , CO, CO ₂ , NO, NO ₂	Засварын газар Машины зогсоол	Жилд 2 удаагийн хэмжилт	Удаа/жил	2	3.0	6.0	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага (MNS 4585:2007) MNS 5013 :2001 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ
Агаарын чанарын загварчлал хийж, загварчлалын үр дүнд суурилсан агаарын чанарын мониторинг хийх	Олборлолт, баяжуулалт явуулж эхэлсний дараа эх үүсвэр тус бүрт	Ялгаралтын хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэсэн үр дүн зэрэгт тулгуурлан 6 сар тутамд 1 удаагийн хэмжилт 24 цагийн турш үргэлжилнэ.	Удаа/жил	1	Дотоод зардал	Дотоод зардал	MNS ISO 4221: 2002, Агаарын чанар. Орчны агаарын хүхрийн давхар ислийн агуулгыг тодорхойлох
Тоосны хэмжилт: PM ₁₀ , PM _{2.5} Тоосны чөлөөт уналт Тоосны найрлага, бүтэц Тоосны тархалт	Ил уурхай Нүүрсний овоолго Хөрсний овоолго Уурхайн дотоод шороон зам Нүүрсний агуулах		Удаа/жил	2	2.0	4.0	MNS 5365:2004, Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга. ISO 9855:1993, Гадаад орчны агаар – Агаар дахь хар тугалгын тоосонцорын хэмжээг атом шингээлт спектрометрийн аргаар тодорхойлох арга
ДҮН						10.0	
Газрын доорх ус							
Ca, Mg, Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , HCO ₃ , Fe, As, Na, K, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, PO ₄ , Ni, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be-ийн агууламж, үнэр,	Баянхошууны худаг-1 559588 4780572 Баянхошууны худаг-2 559725 4779903 Худаг-1	Улиралд нэг удаа (газрын доорх усны чанарын өөрчлөлтөөс	төг/ жил	2	2.0	2.0	MNS 0900:2011 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт (MNS 6148:2010)

Хяналт-шинжилгээ хийх орчин ба үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийх хугацаа ба давтамж	Хэмжих нэгж	Нэгжийн тоо	Нэгжийн үнэ сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
өнгө, булинггар, pH, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин	557643 4778472 Хаданшанд 559555 4776126 Цооног 560369 4776517 Худаг-2 559618 4776243 Шавагтайн худаг 555041 4776354	шалтгаалан давтамжийг өөрчилж болно)					MNS (ISO) 4867:1999 Усны чанар – Дээжлэх Хэсэг 3: Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж MNS (ISO) 5667 11:2000 Усны чанар Дээж авах: 11-р хэсэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж MNS (ISO) 5667-1:2002 Усны чанар-Дээж авах: 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар (Хяналт шинжилгээний үзүүлэлтүүдийг Цант- Уул төслийн талбайн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлангийн 3.5 Газрын доорх ус бүлгийн судалгааны аргазүйг баримтлан ажиллаж суурь судалгааны үр дүнгүүдтэй харьцуулах)
ДҮН						4.0	
Хөрсөн бүрхэвч							
Ялзмагийн агууламж Урвалын усан орчин (pH) Давсжилт, цахилгаан дамжуулах чадвар (EC) Карбонат Хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), кали (K ₂ O)	562510, 4781404, 560836, 4781224 558840, 4779847 553965, 4774118 561775, 4776266 561748, 4777213 ШТС-ын орчимд	Жилд 1 удаа	Жил	2	1.5	3.0	MNS 3307-91 хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга. MNS ISO 0390. Хөрсний чанар. pH тодорхойлох арга MNS 4006:1908 Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мичиганы арга MNS 2143:2000 Хөрсний физик шинж чанарыг тодорхойлох лабораторийн арга. MNS ISO 11269-1:2002 Хөрсний чанар. Хөрсний ургамал бохирдуулагч бодисын нөлөөллийг тодорхойлох арга. 1-р хэсэг: Ургамлын үндэсний өсөлт зогсолтыг хэмжих арга.
Хөрсөн дэх хүнд металл (Cr, Pb, Cd, Ni, Zn)-ын хүлцэх, хортой, аюултай агууламж, мг/кг	560833, 4781224 558844, 4779841 553965, 4774118 561779, 4776263 561751, 4777220	Хөрсний хүнд металлын шинжилгээг жилд 2 удаа буюу хавар 5	Жил	2	1.5	3.0	MNS 5850: 2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 3297:1991. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм,

Хяналт-шинжилгээ хийх орчин ба үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийх хугацаа ба давтамж	Хэмжих нэгж	Нэгжийн тоо	Нэгжийн үнэ сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
	561603, 4779805 561555, 4780460 561077, 4780193	сард, намар 9 сард.					хэмжээ.
ДҮН						6.0	
Ургамлан нөмрөг							
Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц, % Фенелогийн үе шат Биомасс, цн/га Тоосжилтын нөлөө	Өмнөх жилүүдэд хийж байсан 15 цэгт	жилд 1 удаа 8- 10 сард хийх	Жил/төг	1	8.0	8.0	Мониторингийн судалгааны өмнө тухайн бүлгэмдэл болон талбайн фото зургийг авч баримтжуулах, 1х1 м талбайд: Бүрхэцийг тусгагийн аргаар үнэлэх. Зүйл бүрийг бүртгэх, Тухайн талбайгаас ургамлын биомассыг зүйл тус бүрээр газрын гадаргуутай тэнцүүлэн авах, Хяналт, мониторингийн үзүүлэлтүүдийг өмнөх жилүүдийн үр дүнтэй харьцуулан дүгнэлт гаргах.
ДҮН						8.0	
Амьтны аймаг							
Зэрлэг ан амьтдын мониторинг хийх	-Уурхайгаас 5 км-ийн радиуст туруутны мониторингийн цэгэн 3, маршрутын 1 талбай Нүүрс тээврийн зам дагуу	Улиралд 1 удаа	төг	2	2.0	4.0	
ДҮН						4.0	
Дуу шуугиан							
Дуу шуугиан ба доргио чичиргээ	557785, 4780334	Хяналтын цэг дээрхи хэмжилтийг эхний удаа 6 сарын турш сар бүрийн нэгэн	Төг	2	4.0	8.0	MNS 5003:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS 4995 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
	563348, 4780465						
	567313, 4776659						
	557785, 4776631						
	557451, 4773436						
	569176, 4773278						

Хяналт-шинжилгээ хийх орчин ба үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хяналт хийх хугацаа ба давтамж	Хэмжих нэгж	Нэгжийн тоо	Нэгжийн үнэ сая.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
	560140, 4766343	ба 21-ний өдрийн 11:55 - 12:10 (≈12:00) ба шөнийн 11:55 – 00:10 (≈00.00) цагт тогтмол 15 минутын турш хийнэ. Доргио чичиргээний хяналтыг сард 1 удаа хийнэ.					–Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.
	575954, 4767762						
	582311, 4760302						
	Уурхайн бүх төрлийн ажлын байруудад						
ДҮН						8.0	
Цант-Уул нүүрсний ордыг ашиглах төслийн 2024 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал					40 000.0		

4.9.Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			4-5-р сар	6-8-р сар	9-12-р сар		
1	Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар				Уурхайн дарга	
2	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-				Ашиглалтын инженер, БО-ны мэргэжилтэн	
3	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар				Байгаль орчны мэргэжилтэн	
4	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаас				Уурхайн дарга	

4.10.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайн өнөөгийн байдлыг танилцуулах	Өмнөговь аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	V сард	2 000.0 мян.төг
2	Нийт хийгдсэн ажлын хэмжээ, хийгдсэн ажлуудын тайлагнал	Өмнөговь аймгийн БОАЖГ, төслийн нөлөөллийн бүсийн иргэд	Уурхайн дарга, БО-ны мэргэжилтэн	X сард	

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

Байгаль орчныг хамгаалах гол зорилтот ажлуудын төлөвлөлт			
№	Байгаль орчныг хамгаалах чиглэл	Хийгдэх ажлын бүлгийн тоо	Төсөв (сая.төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх	14	14.0
2	Нөхөн сэргээлт	2	14.38
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	2	60.0
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	-	-
6	Осол эрсдэлийн менежмент төлөвлөгөө	5	6.0
7	Хог хаягдлын менежмент	3	2.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	6	40.0
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4	Дотоод зардал
10	Нөлөөлөлд өртөгч талуудад тайлагнах	2	2.0
Гүйцэтгэх нийт ажлын тоо		38	
Зарцуулах нийт төсөв (сая.төг)		138.38	
Байгаль орчныг хамгаалах бусад ажлуудын төлөвлөлт			
11	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх	1.32	1.32
12	Хамтын ажиллагаа	2.0	2.0
Гүйцэтгэх нийт ажлын тоо		2	
Зарцуулах нийт төсөв / сая төг /		3.32	
БОМТ, ОХШХ – 2024 нийт төсөв (сая.төг)		141.7	

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 141.7 сая төгрөгийг төлөвлөж өглөө. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд 14.0 сая төгрөг, нөхөн сэргээлтийн ажилд 14.38 сая.төг, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардалд 60.0 сая.төг, хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардалд 2.0 сая.төг, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 6.0 сая.төг, ОХШХ-т 40.0 сая төг, төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах ажилд 2.0 сая.төг, байгаль орчны хамгаалах бусад ажлын зардалд 3.32 сая.төг зарцуулахаар тооцсон болно.